

Боловсрол судлал**СУРГАЛТЫН ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ ЯВЦ, АРГА ХЭЛБЭР****COGNITIVE PROCESSES AND METHODS OF TRAINING****Э.Батбаяр**

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд сургалт, сурахуйн онолын үндэс, тухайн онолын үзэл санаа ямар агуулгыг илэрхийлдэг талаар мөн танин мэдэхүйн үйл явц нь сургалтын ямар арга хэлбэрээр зохион байгуулдаг талаар товч авч үзсэн болно.

Abstract: In this article, the basis of the theory of teaching and learning, the content of the theory's ideas, and the way in which the cognitive process is organized as a learning method are briefly discussed.

Түлхүүр үг: Сургалт, сурахуйн онол, танин мэдэхүй үйл явц

Key word: Theory of teaching and learning and cognitive processes

Удиртгал. Сургалт гэж аливаа шинжлэх ухааныг танин мэдэхийн тулд сургалтын зорилго, агуулга, орчин, арга барил, сургагч, суралцагч, туршлага зэргийг бүрдүүлж мэдлэг, чадвар бий болгодог ойлголт юм. Тиймээс тухайн өгүүлэлд суралцагчдад мэдлэг, чадвар олгох арга барилыг бүрэн төгс эзэмшүүлэх, хичээл сургалтын явцад онол, арга зүйг ашиглах, зохион байгуулах, үр дүнг харьцуулах шаардлагатай үзэж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Сургалт, сурахуйн онолын үндэс, үзэл санаа: Сурган хүмүүжүүлэх ухаан, сургалтын практикийн түүхэнд догматик, уламжлалт, хөгжүүлэх, прагматик зэрэг олон хэв маягийн сургалтыг хэрэгжүүлж ирсэн. XIX дунд

үеэс эхлэн уламжлалт сургалтыг улам боловсронгуй болгох шаардлага гарч, улмаар хөгжүүлэх сургалтын үзэл санаа газар авах болсон бөгөөд ХХ зуунд олон хувилбарууд бий болсон гэж үздэг байна. Өнгөрсөн зууны дунд үеэс эхлэн когнитив онол, хүмүүнлэгийн онол, конструктив хандлага олон оронд газар авч ХХ зууны эхэн үеэс эхлэн прагматик сургалтын үзэл санаа АНУ болон Европын орнуудад дэлгэрсэн¹.

Манай улсад уламжлалт сургалт, түүнтэй зэрэгцэн хөгжүүлэх болон прагматик сургалтын элементүүд хэрэгжиж ирсэн. Сургалтын ямарваа нэг үзэл санаа онол нь нийгмийн хөгжлийн хэрэгцээ, зорилготой нягт уялдаа холбоотой байдаг. Тухайлбал, социализмын үед шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй хүн бэлтгэх нийгмийн хэрэгцээг хангахад уламжлалт сургалтын арга технологи тохирч байсан бол өнөө үед нийгэм, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээр нийгэм нь сургууль, боловсролоос бие даан хийж бүтээх, өрсөлдөх чадвартай хүн бэлтгэхийг шаардах болсон байна. .

Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангадаг төгс сургалтын онол гэж байдаггүй ба сургалтын үзэл онолуудыг сайн судалж, мөн чанарыг нь танин мэдэж, эдгээрийг бүтээлчээр хэрэглэвэл сургалт үр дүнтэй болох магадлалтай.

Прагматик үзэл санаа. Энэ үзэл санаа нь XIX зууны төгсгөл үед гарч ирсэн ба гол үндэслэгч нь АНУ-ын судлаач, философич Д.Дьюи юм. Тэрээр 1899 онд “Сургууль ба нийгэм” хэмээх алдарт зохиолоо бичсэн бөгөөд 1-р бүлэгт “хүүхэд ширээний ард олон цаг томоотой сууж, багшийг анхааралтай сонсох ажлыг өдөр бүр хийж байна. Хичээл болгон хоорондоо ижилхэн, уйтгартай, хүүхдийн юу бодож, юу хүсэж мөрөөдөж байгаа нь сургууль, багш нар, шийдвэр гаргагч нарт огт хамаагүй, Ийм сургалт хүүхдийг яаж ядрааж залхааж, бас өвдөхөд хүргэж байна” гэсэн дүгнэлт хийжээ. Д.Дьюигийн үзсэнээр тэр үеийн сургалтын хүндийн төв нь багш, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хичээл гэх зэрэг байв. Сургуульд орж буй хүүхэд үүнд цаг хугацаа, хүч тэнхээгээ зарцуулж байна хэмээн шүүмжилсэн. Энэхүү дэвшүүлсэн санаагаа Коперникийн үзэл онол²-той жишиж үзэн сургалтын төв нь “хүүхэд” юм, түүнийг даган бусад зүйл эргэлдэн өөрчлөгдөнө гэж үзсэн.

¹ “Сургалтын зарим үзэл онол: мөн чанар, хэрэглээ” гарын авлага.

² Дундад зууны одон орон судлалд огторгуйн төв бол дэлхий биш нар юм гэсэн санаа дэвшүүлж шинжлэх ухаанд хувьсгал хийж байсан.

Энэ үзлийн төлөөлөгчид хүн аливаа зүйлийг барьж үзэх, үнэрлэх, амтлах зэрэг үйлийг хийж байж сая танин мэддэг гэж үздэг байсан. Орчин үед прагматизм хөгжиж боловсронгуй болсоор байгаа ба тулгуур үзэл санаа нь:

✓ Сургалт суралцагчийн эрэлт хэрэгцээ, сонирхол, туршлагад тулгуурлана.

✓ Суралцагч сурах олон төрлийн үйл ажиллагаанд оролцож байж сая мэдлэг туршлагаа амьдралдаа хэрэглэх чадвартай болно гэх мэт.

Сурахуйн тухай конструктив үзэл санаа. Боловсролын сэтгэл судлалын хамгийн чухал зарчмын нэг бол багш нар сурагчдад зүгээр нэг бэлэн мэдлэг өгөх явдал биш юм. Конструктив онол бол сурахуйн тухай онол гэж барууны тэр дундаа АНУ-ын судлаачид үздэг. Суралцагчид өөр өөрийн санаа бодол, туршлагадаа тулгуурлан өөр өөрийн ойлголт мэдлэг бүтээнэ. Багш мэдлэг бүтээх үйл явцыг хөнгөвчлөхийн тулд дараах арга замаар тусална.

✓ Мэдээллийг сурагчдад утга учиртай, ач холбогдолтой болгох;
✓ Мэдээллийг сурагчдад оновчтой болгох /их биш, хэт хүнд биш болгоно гэсэн үг/;

✓ Нээлт хийх аятай боломж бүрдүүлж өгөх;
✓ Суралцагчдад өөрсдөө санаа бодлоо хэрэгжүүлэх боломж олгох;
✓ Суралцагчдад үзэж байгаа зүйлээ ухаарч ойлгох боломж өгөх;
✓ Суралцагчдад эзэмшсэн сурах арга барилаа ухамсартай ашиглах боломж өгөх гэх мэт.

Эдгээр санаан дээр суурилсан суралцахуйн онолуудыг “сурахуйн конструктив онолууд” гэж нэрлэдэг.

Конструктив хандлага. Конструктив хэмээх үг нь **construct** буюу бүтээх, зохиох, барих гэсэн утгатай англи үг юм. Хүүхэд багадаа конструктор хэмээх тоглоомоор тоглож энгийн эд зүйлээр байшин, машин болон бусад дуртай зүйлээ зохион бүтээдэг. Конструктив хандлага нь сурахуйн тухай нэг л урсгал бөгөөд түүнд бид бүтээлчээр хандаж ашиглах нь зүйтэй. Энэ хандлагыг сурахуйн бусад хандлага, үзэл санаа, арга барилтай хослуулан хэрэглэх нь зөв зүйтэй шийдэл юм.

Оюун ухааны үйлдэл шатлан төлөвших онол. Оросын нэртэй сэтгэл судлаач П.Я.Гальперин 1960-аад оны үед удаан хугацааны туршилт судалгааны үр дүнд “оюун ухааны үйлдэл шатлан төлөвших” онол боловсруулсан. Энэ онолын гол санаа нь сурагч шинэ үйлдэл эзэмших нь анхандаа түүнийг гүйцэтгэх нөхцөлд идэвхтэй баримжаалахыг шаарддаг, гадна орчны юмстай гүйцэтгэх үйлдэл нь дотоод оюун ухааны үйлдэл болж шилжих замаар хүртэх, сэтгэх, үйлдэл төлөвшдөг явдал юм. Хүртэх, сэтгэх үйлдэл төлөвших үе шат:

- ✓ үйлдлийг эзэмших сэдэл бий болгох үе
- ✓ үйлдлийн тухай баримжаалал өгөх үе
- ✓ үйлдлийг биечлэн хийж гүйцэтгэх үе
- ✓ үйлдлийг ярьж гүйцэтгэх үе
- ✓ дотроо бодож гүйцэтгэх үе
- ✓ үйлдлийг олон удаа хийсний эцэст аяндаа хийх үе

Хоёр. Уламжлалт сургалтын арга

Уламжлалт сургалт. XIX зууны дунд үеэс багш мэдлэгийг сурагчдад тайлбарлан ярьж ойлгуулах ба хүүхэд ойлгосон зүйлээ багшдаа ярьж өгөх болсноор уламжлалт сургалтын суурь бий болсон. Уламжлалт сургалтын явцад сурагчдаар дасгал хийлгэх, бие даалган ажиллуулахыг эрхэмлэдэг. Гэвч багш нар сурагчдын хийх, бодох, ярих зэргийг авч хийдэг болсон нь багшийн тайлбарласныг цээжлэн тогтоогоод эргүүлж мэдээлдэг идэвхгүй нэгэн болгосон. Сүүлийн үед уламжлалт сургалтаас татгалзах гэсэн сөрөг өнгө аясаар хэрэглэх болжээ. Гэтэл уламжлалт сургалт нь олон сайн талтайг харгалзан үзэх нь зүйтэй. Тухайлбал, сурагчдын мэдлэгийг бататгах зорилгоор олон янзын даалгавар, дасгал, бодлого зэргийг ашигладаг, уламжлалт сургалтын мөн чанарын давуу тал болох сурагчдад системтэй их мэдлэг олгодог¹ зэргийг дурдаж болно.

Хөгжүүлэх сургалт. XIX зууны дунд үеэс эхлэн хүүхдийг хөгжүүлэх, түүнд бие дааж сэтгэн бодох арга барил эзэмшүүлэх үзэл /Европын орон тэр дундаа Германы дэвшилтэд сурган хүмүүжүүлэгч А.Дистервег/ хүчтэй болж улмаар XX зуунд хөгжүүлэх сургалт бие даасан онолын нэгэн урсгал

¹ Уламжлалт сургалтын мөн чанарын талаарх ойлголтыг Ичинхорлоо.Ш., Сургалтын зарим үзэл онол: мөн чанар, хэрэглээ, 2013 он, 6-7 дахь тал

болсон байна.1920-1930 оны үед Оросын нэртэй сэтгэл зүйч Л.С.Выготский хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх асуудлаар өөрийн үзэл онолоо дэвшүүлснээр хөгжүүлэх сургалтын сэтгэл зүйн үндэс тавигдсан. Тэрээр оюуны хөгжлийн ойрын бүсийн онолдоо хүүхдийн оюун ухаанд хөгжлийн өнөөгийн ба ойрын бүс гэж үзсэн байна.

Багш нар сургалтаа зохион байгуулахдаа хүүхдийн оюуны хөгжлийн өнөөгийн бүст тулгуурлаж, ойрын бүс рүү чиглүүлэн явуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

Хөгжүүлэх сургалтын талаар Оросын судлаачдын хийсэн бүтээлүүдэд гол төлөв хүүхдийн оюун ухааны хөгжлийг авч үзсэн онцлогтой.1980-аад оноос Оросын шинийг санаачлагч багш нар “Хамтын сурган хүмүүжүүлэх ухаан” гэсэн шинэ үзэл санаа, арга барилыг дэвшүүлсэн. Хүүхдийг амжилттай сурган хүмүүжүүлэх, хөгжүүлэх нь чухал гэдгийг онцолсон. Жишээлбэл, хүүхэд амжилттай сурч хөгжихөд багш туслах биш түүний хамтран зүтгэгч байх, хүүхдэд өөрийнх нь хүч тэнхээг мэдрүүлж, өөртөө итгэдэг болгох, хүүхдийг тодорхой бэрхшээлтэй учруулж, түүнийг даван туулах арга барилтай болгох, хүүхдэд тал бүрийн сонголт хийх боломж олгох гэх мэт.

Асуудал шийдвэрлэх сургалт. Орчин үед хүний амьдрал олон төрлийн асуудлаар дүүрэн, тиймээс өсвөр үеийнхэнд амьдралынхаа аливаа асуудлыг ул суурьтай авч үзэн шийдэх арга барилыг сурах явцад эзэмшүүлэх явдал сургалтын нэг чухал зорилт болсон. Нийгмийн хөгжил, шинжлэх ухаан техникийн дэвшил зэрэг хүмүүсээс бүтээлч чадавх улам их шаардах болсон өнөө үед суралцагчийн бүтээлч чадварыг хөгжүүлэх явдал чухал хэвээр байна. Энэ агуулгаараа асуудал шийдвэрлэх сургалт хэзээ ч хуучрахгүй бөгөөд багш нар энэ сургалтын үзэл санаа, арга зэргийг бүтээлчээр хэрэглэж цааш хөгжүүлэх явдал чухал юм.

Программчилсан сургалт. Уг сургалтын үндэслэгч нь АНУ-ын судлаач Н.Краудер, Б.Скиннер, С.Пресси, Оросын судлаач Н.Ф.Талызина, А.М.Матюшкин, Л.Н.Ланда нар юм. Энэ сургалтын гол зорилго нь сургалтын процессыг оновчтой удирдан жолоодох ажиллагааг сайжруулах, сурах үйл ажиллагааг урьдаас төлөвлөн хөтөлж, сурагч сурах үйлийн системийн үйлийг гүйцэтгэснээр амжилттай сурах явдал юм.

Программчилсан сургалтын мөн чанар нь дараах зүйлээр тодорхойлогддог. Тухайлбал, хичээлийн материалыг тодорхой хэсгүүдэд

хуваадаг, хичээлийн процесс нь дэс дараатай альбомуудаас бүрдэх ба алхам болгон нь тодорхой хэмжээний мэдлэг, түүнийг эзэмших оюуны үйлүүдээс бүрддэг, алхам бүр нь хяналтаар төгсдөг, сурагч хяналтын даалгаврыг зөв хийвэл дараагийн алхам руу шилждэг, сурагч хяналтын даалгаврыг буруу хийвэл алхам руу буцан орж нэмэлт тусламж, тайлбар авдаг, сурагч болгон алхмыг өөртөө тохирсон хурдаар гүйцэтгэдэг, хяналтын үр дүн багш, суралцагчдад ил тод, сурагч алхам бүрийг өөрт тохирсон хурдаар гүйцэтгэдэг, багш зохион байгуулах үүрэг гүйцэтгэж сурагч нэг бүртэй ажилладаг, сургалтын үйл явцад техник хэрэгслийг өргөн хэрэглэдэг. Уг сургалт нь дотроо программчилсан сургалтын шугаман систем, энэ систем нь сурагч бүр алхмыг программд урьдчилан боловсруулсан дарааллаар хийж гүйцэтгэх болон программчилсан сургалтын салаалсан систем, түүний алхмын бүтэц нь 3 хэсэгтэй ба ялгаатай тал нь хянах хэсэг нь асуулт ба түүнд өгөгдсөн олон янзын хариултаас бүрдэх гэж 2 төрөл байдаг.

Сурагч төвтэй сургалт. Францын нэрт соён гэгээрүүлэгч Жан Жак Руссо “Эмиль ба хүмүүжлийн тухай” зохиолдоо хэрэглэсэн. Тэрээр “багш хүмүүжүүлэгч нар хүүхдийн ойлгохгүй байгаа зүйлийг хүчээр ойлгуулах гэсээр байгаад түүний сурах дур сонирхлыг үгүй хийдэг. Хүүхэд бодит амьдрал орчноос хэрэгтэй, ашигтай зүйлээ өөрөө олоод авдаг ухаалаг нэгэн учраас түүнийг албадахгүй орхих юм бол тэр хэрэгтэй бүхнээ өөрөө олоод сурна гэсэн санааг дэвшүүлсэн. Сурагч төвтэй сургалт нь суралцагчийн авьяас чадавх, хэрэгцээ сонирхол, эрх, эрх чөлөө зэргийг эрхэмлэсэн, түүнд чөлөөтэй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж чадсан сургалтын нэг чиглэл ба Европын олон оронд амжилттай хэрэгжсэн.

Сургалтын үр дүн. Эцэст нь хүн шинэ мэдээллийг урьд нь эзэмшиж байсан зүйлтэйгээ харьцуулж, шүүлтүүрээр нь боловсруулж дууссаны дараа оюун ухаандаа нэгтгэдэг. Энэ үйл явцын үр дүнд бий болсон мэдлэг нь урьд өмнө олж авсан мэдээллүүд болон тухайн хүнд танилцуулж байсан мэдээллүүдээс ялгаатай болох ойлголт юм.

ТАНИН МЭДЭХҮЙН ОЙЛГОЛТ, ҮЙЛ ЯВЦ

Танин мэдэхүйн үндсэн ойлголт. Нийгмийн танин мэдэхүйн онол нь бидний өмнө нь тодорхойлсон энэхүү ерөнхий санаанаас гадна суралцах үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг ойлгоход маш хэрэгтэй бусад ойлголтуудыг багтаасан болно. Жишээлбэл, бидний хүлээн авсан шинэ

мэдээлэл бүрийг урьд өмнө тохиолдож байсан бусад ижил төстэй туршлагатай уялдуулан шалгаж үздэг гэж заасан байдаг.

Нөгөөтэйгөөр, энэхүү онол нь "ажиглалтын сургалт" гэж нэрлэгддэг түүнийг харуулсан бусад хүмүүсийг ажигласнаар л шинэ зан төлөв, санаа бодлыг олж авах боломжтой гэдгийг баталж байна. Нэмж дурдахад нийгмийн танин мэдэхүйн онолоос үүдэлтэй сургалтын үйл явц нь тухайн орчин биш ч гэсэн шинэ мэдээллийг хамгийн сайн аргаар олж авахын тулд субъектүүдын сэтгэл хөдлөлийн чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг хамгийн тохиромжтой.

Танин мэдэхүйн сургалт. гэдэг нь уламжлалт сургалтын үзэл баримтлалыг хүний тархины үйл ажиллагааны талаар сүүлийн хэдэн арван жилд шинээр нээсэн нээлтүүдтэй хослуулсан нэр томьёо юм. Тиймээс энэ нь бидний оюун ухаан үр дүнгээ сайжруулахын тулд хэрхэн ажилладгийг харгалзан үздэг сургалтын хэлбэр юм. Танин мэдэхүйн сургалтын онол нь шинэ мэдээлэл хүлээн авах бүрдээ үүнийг цээжлэхээсээ өмнө тархиа боловсруулж, шүүж авдаг болохыг нээснээс үүдэлтэй юм.

Танин мэдэхүйн зан үйлийн онол. Танин мэдэхүйн зан үйлийн онол бол клиник сэтгэлзүйн ертөнцөд хамгийн чухал байр суурь эзэлдэг. Энэ нь хүний зан байдал, сэтгэл хөдлөл, итгэл үнэмшлийн хоорондын харилцааг судлахад чиглэгддэг. Эдгээр гурван хүчин зүйл харилцан бие биедээ нөлөөлдөг бөгөөд хүний туршлагыг ойлгоход үндэс суурь болно. Танин мэдэхүйн зан үйлийн онолыг сэтгэлзүйн эмчилгээний ертөнцөд түгээмэл ашигладаг. Энэхүү хандлага нь тухайн хүний бодол санаа, итгэл үнэмшил, зан аашийг өөрчлөх, тэдний сэтгэлийн байдал, ертөнцтэй харьцах харьцааг дээшлүүлэхэд чиглэгддэг. Сургалтын түвшинд танин мэдэхүйн зан үйлийн онол нь бидний цээжлэх мэдээлэлд онцгой нөлөө үзүүлдэг гурван элемент байдаг гэж өөрсдийгөө хэрхэн хардаг, хүрээлэн буй ертөнцийг хэрхэн хүлээн авч байгаа байдал, бидний бодож байгаа байдал зэрэг нь ирээдүйг хөгжүүлэх болно гэж хэлдэг.

Танин мэдэхүйн үйл явцын онол. Танин мэдэхүйн сургалтын онол нь бид зөвхөн шинэ мэдлэг олж авдаггүй гэдгийг баталж байна: шинэ мэдээллийг дотооддоо нэвтрүүлэх бүрдээ бид өмнө нь хадгалж байсан мэдлэгийнхээ өөрчлөлтийг бий болгодог. Тиймээс энэхүү онолын тайлбарласан үйл явц нь бусад ижил төстэй онолуудаас нэлээд өөр юм. Нэг талаас энэ сэтгэлзүйн онол нь бид хэзээ ч эхнээс нь сурч эхлэх боломжгүй

гэж баталж байна. Эсрэгээр, хүн аливаа сэдвээр урьд өмнө сурч мэдсэнээр олж авсан урьдчилсан таамаглал, хасалт эсвэл санаа бодлоороо үргэлж тодорхой мэдлэгтэй байдаг. Үүнээс үүдэн аливаа шинэ сургалтад шинэ мэдээлэл тухайн хүний тархинд аль хэдийн орсон байсан зүйлтэй харьцах шаардлагатай болдог. Энэ нь шинэ мэдлэгийг танилцуулсны дагуу хадгалах боломжгүй, харин хувь хүний оюун ухааны шүүлтүүрээр удирддаг гэсэн үг юм. Танин мэдэхүйн сургалтын онол нь шинэ мэдлэг олж авах дөрвөн алхмыг ярьдаг. Дараа нь бид тус бүрдээ яг юу бүрдэхийг харах болно.

Сурах гэж юу вэ? Хүн яаж сурдаг вэ? гэдэг асуудлыг судалдаг шинжлэх ухааныг когнитив сэтгэл судлал буюу суралцахуйн сэтгэл судлал¹ гэж нэрлэдэг бөгөөд орчин үед олон чиглэлтэйгээр хөгжиж байна. Хийсвэр түвшинд боловсролын философи, боловсролын онолын загварууд энд яригддаг бөгөөд эндээс хоёр чиглэл давуу хөгжиж ирсэн.

Мэдлэг бүтээх арга. Суралцагч харах, сонсох, хүртэх зэрэг сэрж мэдрэх эрхтнийхээ тусламжтайгаар мэдээллийг хүлээн авна. Өөрийн гэсэн утга өгөгдөөгүй, зөвхөн сонссон, харсан мэдээлэл нь хүний богино хугацааны санамж дээр ирж боловсрогдоно. Гэвч маш их хэмжээний мэдээлэл энэхүү санамжид хүрч чадалгүйгээр гээгдэх боломжтой байдаг. Мэдээллийн алдагдлыг багасгахын тулд суралцагчдын амьдралд байдаг, тэдний сонирхлыг татсан, тэдэнд сэдэл төрүүлэх сэдэв, асуудлаас сургалтыг эхлэх нь зүйтэй. Энэ нь дурын нэг асуудал биш, харин сургалтаар авч үзэх шинжлэх ухааны асуудлыг “дотоо агуулсан” байх учиртай.

Мэдээллийг боловсруулж, мэдлэг болгох. Мэдээллийг боловсруулах, мэдээллийг мэдлэг болгох хоёр арга зам байна. Гаднаас өгч буй мэдээлэл буюу багшийн хэлж ярьсан зүйлийг тэр чигээр нь хүлээн авах. Энэ үед хүлээн авсан мэдээлэл нь “цээжилсэн мэдлэг” байдлаар салангид байж байгаад мартагдана. Багш судлах зүйлийн талаар суралцагчид ямар төсөөлөл, мэдлэгтэйг тандаад, түүнийг тооцон сургалтыг зохион байгуулах нөхцөлд сурагчдын мэдлэг өмнөхөөс илүү цэгцтэй, илүү зөв, илүү өргөн хүрээний мэдлэг болон буцаж хадгалагдана.

Мэдээллийг хадгалах. Гадаад мэдээлэл ба өөрийн төсөөлөл, сонирхолд суурилан өөрийн зорилго, стратегийг идэвхтэй бүтээнэ. Сурч буй хүнд бодол санаа, сэтгэлгээгээ хянаж, шалгаж, зохицуулдаг нөөц байдаг. Энэхүү метакогнитив процессийг хариу үйлдлээр хэрэгжүүлдэг.

¹ http://ncle.mn/esd/files/1.2.2_gadnii_udirdlagatai_suraltsahuigaas_uuriin_udirdlaga.pdf

Өөрийн суралцахуйг тодорхой зорилгод хүрэхэд чиглүүлнэ. Иймд танин мэдэхүй, сэтгэлгээ, сэдэл тэмүүлэл, хандлагатай холбоотой үйл явцаа энэхүү зорилгод зохицуулан, боловсронгуй болгоно. Сургалтын амжилт нь зөвхөн гадаад нөхцөл байдлаар (материаллаг орчин) тодорхойлогдохгүй. Харин сурч буй хүн өөрийн танин мэдэхүй, сэтгэлгээ, сэдэл тэмүүлэл, хандлагаа сургалтын амжилттай хэрхэн уялдуулж байгаа нь шийдвэрлэх үүрэгтэй.

Мэдээллийг хэрэглэх. Өөрийн удирдлагатай суралцахуй Танин мэдсэн, өөрөө бүтээсэн мэдлэг, чадвар хандлагаа хөгжүүлэх ямар ч нөхцөл байдалд шилжүүлэн хэрэглэх чадварыг хэлнэ. Өөрийн удирдлагатай ба гаднын удирдлагатай суралцахуйг хэрэглэхдээ:

- ✓ Хаана, хэнд, хэдийд аль нь давуу байх вэ?
- ✓ Холимог хэлбэр
- ✓ Үүргийн хуваарилалтын ач холбогдол
- ✓ Мэргэжлийн соёл зэргийг нягталж тунгаах хэрэгтэй болно.

Суралцахуй ба багшлахуйг дараах байдлаар ойлгож, хэрэгжүүлэх хэрэгтэй.


1. Сурч буй хүний үйл ажиллагаа нь өөртөө хариуцлага хүлээсэн, өөрийн удирдлагатай, мөн багийн үйл ажиллагаанд баримжаалсан байна. Түүнчлэн ингэж сурахад шаардлагатай когнитив ба социал цогц чадамжийг эзэмших ба танин мэдэхүйн аргыг мөн сурах учиртай.

2. Когнитив цогц чадамж ба хариуцлагатай, өөрийн удирдлагатай суралцахуйн цогц чадамжийг ижил хэмжээнд дэмжих, ингэхдээ харилцан адилгүй суралцагчдын бие даасан болон багаар ажиллах сургалтын хэлбэрүүдийг ашиглах. Сургалт нь сурч буй хүмүүс, багшилж байгаа хүний хамтын үйл ажиллагааны үр дүн гэж ойлгох.

3. Багшийн ажил: Багийн хүрээнд сургалт ба түүний орчныг сайжруулах ахисан түвшний, удирдлага бүхий өөрчлөлтийн үйл ажиллагаа (хичээлийн хөгжил). Төсөл хэрэгжиж байгаа орон нутагт мэргэжил дээшлүүлэх замаар сургалтын хөтөлбөр ба сургах арга зүйгээ байнга өөрчлөх.

Дээрх агуулгын хүрээнд судалгаа авч үзэхэд:

График 1.Багш суралцагчдад мэдээллийг хүргэж, хүлээн авахад бэлддэг байдал




Хүснэгт 1. Багш суралцагчдад мэдээллийг хүргэж, хүлээн авахад бэлддэг байдал

№	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
1	Багш лекцийн хичээлд ашиглах танилцуулгыг бэлддэг байдал	35	90	52	6
2	Багш лекцийн хичээлд ашиглах нэмэлт материалаар хангадаг байдал	30	76	64	13
3	Багш лекцийн хичээлийг ойлгомжтой тайлбарладаг байдал	36	94	45	9

“Мэдээллийг хүртэж хүлээн авахад бэлдэх” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хувааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-17.5, сайн үнэлгээ-43.3 буюу дийлэнх хувийг, дунд-26.3, хангалтгүй-4.6 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 2. Мэдээллийг хүртэж хүлээн авах байдал



Хүснэгт 2. Мэдээллийг хүртэж хүлээн авах байдал

№	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
1	Лекцийн хичээлийн агуулгын тодорхой байдал	32	95	55	3
2	Хичээлийг дэлгэрүүлж унших материалыг зааж өгдөг	33	83	61	8
3	Лекцийн хичээлийг дэлгэрүүлж унших хэрэгцээ шаардлагатай	28	95	56	6

“Мэдээллийг хүртэж хүлээн авах байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хувааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-15.5, сайн үнэлгээ-45.5 буюу дийлэнх хувийг, дунд-28.6, хангалтгүй-2.8 буюу дунджаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 3. Мэдээллийг ухаарч ойлгох байдал




Хүснэгт 3. Мэдээллийг ухаарч ойлгох байдал

№	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
1	Хичээлийн агуулга логик дэс дараалалтай байдаг	29	90	61	5
2	Хичээлийн явцад шинэ мэдлэг олж авдаг	30	100	50	5
3	Хичээлийн төгсгөлд өөрийн гэсэн дүгнэлтийг хийж чаддаг	33	77	67	7

“Мэдээллийг ухаарч ойлгох байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хувааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-15.3, сайн үнэлгээ-44.5 буюу дийлэнх хувийг, дунд-29.6, хангалтгүй-2.8 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 4. Мэдээллийг бататгаж мэдлэг олгох байдал




Хүснэгт 4. Мэдээллийг бататгаж мэдлэг олгох байдал

№	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
1	Лекцийн хичээл, семинарын хичээл уялдаа холбоотой байдаг	37	82	59	5
2	Семинарийн хичээлээр зөвхөн лекцийн хичээлийг бататгадаг	33	83	59	8
3	Семинарын хичээлээр бие даана жиллаж чаддаг	40	88	50	5

“Мэдээллийг бататгаж мэдлэг олгох байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хувааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-18.3, сайн үнэлгээ-42.1 буюу дийлэнх хувийг, дунд-28, хангалтгүй-3 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 5. Мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших




Хүснэгт 5. Мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших

№	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
1	Онолын мэдлэгийг ашиглах боломж гардаг	34	89	58	3

2	Кейс, бодомж дээр ажиллахад онолын мэдлэг хангалттай байдаг	29	91	56	8
3	Лекцийн хичээлээр олж авсан мэдлэг мэдээлэл дасгал, бодлого ажиллахад ашиглагддаг.	33	83	60	7

“Мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хувааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-16, сайн үнэлгээ-43.8 буюу дийлэнх хувийг, дунд-29, хангалтгүй-3 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 6. Мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдал



Хүснэгт 6. Мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдал

№	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
1	Би өөрийгөө үнэлж шүүмжилж чаддаг	34	91	56	2
2	Би өөрийн алдааг хүлээн зөвшөөрч илүү сайжруулах арга зам хайдаг	42	83	55	3
3	Багшийн үнэлгээтэй би санал нийлдэг	34	79	58	9

“Мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хувааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-18.3, сайн үнэлгээ-42.1 буюу дийлэнх хувийг, дунд-28.1, хангалтгүй-2.8 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

ДҮГНЭЛТ

Иймд багш нар суралцагчдад мэдлэг, мэдээллийг хүргэх, сургалт зохион байгуулахад сурган хүмүүжүүлэх ухааны мэдлэгээс гадна сэтгэл зүйн шинжлэх ухааны талаарх ойлголт мэдлэгийг, сургалтын үйл явцтай

хэрхэн уялдуулах, сургалтад удирдагчийн байр сууринаас хандах бус суралцагчийн танин мэдэх үйл явцад оролцогч, чиглүүлэгч, зөвлөгчийн байр сууринаас оролцох, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжигч болохыг ойлгуулах арга зүйг сургалтад түлхүү ашиглах нь зүйтэй гэж үзлээ.

Багш хүний өдөр тутмын хийж гүйцэтгэж буй сургалт, түүний талаарх онол, үзэл санаа, ойлголт ухагдахуун, сургалтын төрлөөс шалтгаалан ямар арга, арга зүйг хэрэглэх, энэхүү арга зүйг хэрэглэж сурах нь бидний олгох гээд байгаа мэдээллийг суралцагчид хэрхэн өөрийн болгож боловсруулж сурах, сурах үйл ажиллагаа болгох шаардлагыг олж харан өөрийн судалгааны ажлаас эх сурвалж авч асуулга хэлбэрээр 100 гаруй суралцагчыг хамруулан, багш мэдээллийг хүртэж хүлээн авахад бэлдэх, бататгаж мэдлэг олгох байдал суралцагч мэдээллийг хүлээн авах, ухаарч ойлгох байдал, мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших, мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдлаар тус тус асуулга боловсруулахад маш сайн, сайн үзүүлэлт 60%-70% хувь, 30%-40% хувьд дунд, хангалтгүй гэж хариулсан нь сурах, суралцах үйл явцад суралцагчийн хандлага мөн багшийн заах арга зүй ямар түвшинд байгааг тодорхой харуулж байна гэж дүгнэлтэд хүрлээ.

ЭХ СУРВАЛЖ

1. НОМ, СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА

1. Ш.Ичинхорлоо., Сургалтын зарим үзэл онол: Мөн чанар, хэрэглээ. УБ хот, 2013 он
2. Ш.Ичинхорлоо., Дээд сургуулийн сургалт: Онол, арга зүй, УБ хот, 2015 он
3. Ш.Ичинхорлоо., Сурахуй хийгээд сурах арга, УБ хот, 2019 он
4. Жантэн Каяа., Багшид өгөх зөвлөгөө, Емпати хэвлэлийн газар, 2 дахь хэвлэл
5. ХСИС-ЭЗНУС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны багшийн хөгжлийн асуудалд: Онол, арга зүйн хэлэлцүүлгийн эмхэтгэл, УБ хот, 2018 он

2. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. [https://mn.wikipedia.org/wiki/
http://ncle.mn/esd/files/1.2.2_gadnii_udirdlagatai_suraltsahuigaas_uuriin_udirdlaga.pdf](https://mn.wikipedia.org/wiki/http://ncle.mn/esd/files/1.2.2_gadnii_udirdlagatai_suraltsahuigaas_uuriin_udirdlaga.pdf)

---o0o---